



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 228


Улаанбаатар хот

“Фин стар ХЗХ”-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.5, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 9.7.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Фин стар ХЗХ”-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. Хоршооны хадгаламж, зээлийн үлдэгдэл, төлбөр тооцоог барагдуулахыг “Фин стар ХЗХ” /Ц.Оюунжаргал/-нд үүрэг болгосугай.
3. “Финстар ХЗХ”-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийлгэхийг Хяналт шалгалтын газар /Т.Жамбаажамц/-т, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000735